

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН
2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.07.01

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан батлуулсан нэгжүүдийн 6 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

Үнэлэлт

Нэгжүүдийн 5 дугаар сарын төлөвлөгөөнд тусгагдсан нийт ... ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%		
ЗСХ	26	15	-	2	1	2	5	-	67.3
ТНУАСХ	10	8	-	-	-	1	1	-	83.0
ГХБАБМХ	13	10	-	-	1	-	2	-	80.8
Дүн	49	33	-	2	2	3	8	-	74.1

Дүгнэлт:

1/Тайлант сард Захиргаа, санхүүгийн хэлтэс 26 ажлыг төлөвлөж хэрэгжүүлснээс 67,3%-ийн биелэлттэй, өмнөх сарын төлөвлөгөөний биелэлттэй харьцуулахад 20.34%-иар буурсан дүнтэй байна.

2/Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс 10 ажлыг төлөвлөж хэрэгжүүлснээс 83,0%-ийн биелэлттэй, өмнөх сарын төлөвлөгөөний биелэлттэй харьцуулахад 14,0%-иар буурсан дүнтэй байна.

3/Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс 13 ажлыг төлөвлөж хэрэгжүүлснээс 80,8%-ийн биелэлттэй, өмнөх сарын төлөвлөгөөний биелэлттэй харьцуулахад 12,57%-иар буурсан дүнтэй байна.

4/Төвийн дүнгээр 49 ажлыг төлөвлөж хэрэгжүүлснээс 74,01%-ийн биелэлттэй, өмнөх сартай харьцуулахад 17.82%-иар буурсан дүнтэй байна.

5/ЗСХ-ийн төлөвлөсөн

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах, ажлын байрны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээ авах

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн болон ажлын байранд тулгамдаж буй асуудлуудыг хамарсан судалгаа хийх

- Захирлын шуурхай болон багийн хурлыг дотоод журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, хагас жилийн байдлаар биелэлтийг гаргаж удирдлагад танилцуулах

-Захирлын зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулалтаар хангаж, зөвлөлийн гишүүдэд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, төслийг цахимаар файлыг илгээж, хурлын тэмдэглэл, шийдвэрийн төслийг боловсруулж, удирдлагад танилцуулж, холбогдох ажилтанд шилжүүлэх

-Ажилтнуудын 5 дугаар сарын цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад дүн шинжилгээ хийх гэсэн 5 ажил хэрэгжээгүй тасарсан байна.

6/ ТНУАСХ-ийн төлөвлөсөн Галт тэрэгний зурмагийн шинжилгээ, хяналтыг автоматжуулах системийн судалгааны ажлыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, ГХБАБМХ-ийн төлөвлөсөн Төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн зорчигч, ачаа тээврийн үзүүлэлтүүдийг харуулсан мэдээлэл бэлтгэн төвийн viber хуудсанд байршуулах, Төмөр замын тээврийн хэрэгслийн баталгаажуулалтын баримт бичиг боловсруулах ажлыг эхлүүлэх гэсэн 3 ажил хэрэгжээгүй тасарсан байна.

7/ ЗСХ-ийн төлөвлөсөн Орон сууцны БУА-ыг үргэлжлүүлэхэд шаардлагатай баримт бичиг, зөвшөөрлүүдийг гүйцэтгэгчтэй хамтран албажуулах, хяналт тавьж ажиллах, КОЙКА хамтын ажиллагааны байгууллагатай хамтран төвийн барилгын зураг төсөл боловсруулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг ханган ажиллах, ТНУАСХ-ийн төлөвлөсөн КОЙКА-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран төвийн барилгын зураг төслийн ажил хийж гүйцэтгэх байгууллага сонгон шалгаруулах тендер зарлах ажиллагаанд дэмлэг үзүүлж ажиллах гэсэн 3 ажлын “хэрэгжилт хангалтгүй” байна.

8/ ЗСХ-ийн төлөвлөсөн 4 ажлын тухайн сард “хүрэх түвшин”-ийг бичээгүй, 6 ажлын биелэлтийг гаргаж, эйбл системээр хаагаагүй байна.

9/ Ажилтнуудын ажлын үр дүнг сар, улирал, хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх зохицуулалт болон хариуцлагын механизм хөдөлмөрийн дотоод журамд байхгүйгээс ажил хийдэх, цалгардах, удаашрах үндсэн шалтгаан болж байна.

Санал зөвлөмж:

1/ Төлөвлөсөн ажлыг “төлөвлөсөн хугацаа”-нд гүйцэтгэж Хөдөлмөрийн тухай хуулийн 42.2.1-д заасан “ажил үүргээ биечлэн, үнэнчээр, өөрийн үр чадвар, боломжоо дайчлан зохих ёсоор гүйцэтгэх”, 42.2.9-д заасан “ажил олгогчийн шаардсанаар ажил үүрэгтэй холбоотой мэдээллийг ажил олгогчид үнэн зөвөөр өгөх, хийсэн ажлаа тайлагнах” гэсэн ажилтны үндсэн дагаж мөрдөх;

2/ Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.2-т зааснаар “ажилтнаас хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх, хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаардах”, 43.2.6-д зааснаар “ажилтныг ажлаар хангаж, ... зааварчилгаа өгөх” гэсэн ажил олгогчийн үндсэн үүргийг хэрэгжүүлж удирдлагаас тавих хяналтыг сайжруулах;

3/ Хөдөлмөрийн дотоод журмын 2.4, 2.5-д зааснаар захирлын шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутамд зохион байгуулж гүйцэтгэсэн ажил, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг сонсох ажлыг хэвшүүлэх;

4/ Захирлын зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлэх, Захирлын зөвлөлийн хурлаар 2022 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хойшлуулалгүй тухай бүр товлосон хугацаанд хэлэлцүүлэх;

5/ Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх журмыг яаралтай батлуулах, Хөдөлмөрийн дотоод журамд хариуцлагын зохицуулалтыг шинээр тусгаж батлуулах.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА



Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДХА



Э.ОСОРЖАМАА